

**ӨВӨР МОНГОЛЫН ХИШИГТЭН ХОШУУНЫ ЗУУХЫН ГОЛЫН ХАДНЫ
БИЧЭЭС ДЭХ ДӨРВӨЛЖИН ҮСГИЙН ШИНЖЛЭЛ**

ХОШУУД ЦЭНГЭЛ

Товч агуулга. Эл өгүүлэлд Өвөр Монголын Хишигтэн хошууны Зуухын голын бэлчрээс шинээр олдсон XIII-XIV зуунд холбогдох уйгуржин монгол, хятад, төвд, кидан, дөрвөлжин үсгийн 20 гаруй дурсгалаас дөрвөлжин үсгийн бичээсийг сонгон судлаад дараах үзэлтийг дэвшүүлсэн байна. Үүнд: 1-рт: Уг бичээсийг бичсэн он цаг (жиюаний 15-р он буюу 1278)-ийг тодруулах тухайд өөрийн саналаа дэвшүүлэв. 2-рт: Эл дөрвөлжин үсгийн бичээсийн төрөл зүйл (аян замын бичээс, ван ноёдын албан бичгийн хуулбар, хааны оны цолтой тэмдэглэл, дөрвөлжин үсгийн цагаан толгой)-ийг ялган тодруулж өгөв. 3-рт: Тухайн үеийн дөрвөлжин бичгийн хэл зүй, бичлэгийн онцлогийн талаар авч үзсэн байна.

Түлхүүр үг. Хишигтэн хошуу, хадны бичээс, дөрвөлжин үсэг, жиюаний 15-р он

Өвөр Монголын Хишигтэн хошууны төв, Бяруу балгасаас урагшаа 40 гаруй км-т байгаа Шар мөрний салаа урсгал, Зуухын голын дагуу орших Гуаншинюань (广兴源 Guang xing yuan) гэдэг тосгоны ойр хавийн нэгэн хадан дээр, нэг бүлэг эртний бичээс мэт зүйл байгаа тухай, тус газрын Ой шугуйн талбай хамгаалах газрын ажилтан Төгсбаярын дамжуулж ирүүлсэн сургийг нягтлахаар, судлаач миний бие, 2018 оны 11-р сард Хишигтэн нутагт очин, анхны судалгаагаа хийж, уйгуржин монгол, хятад, төвд, кидан, дөрвөлжин үсгийн 20 гаруй дурсгал байгааг илрүүлэн тогтоосон билээ.

Бичээсийг үзэхэд үндсэндээ хоёр янзын байр байдалтай байгаа нь мэдэгдэв. Тэгш, гөлгөр, налуу хадны нүүрэн тал дээрх бичээс нь он жил, цагийн эрхээр элэгдэн балархайшаад, хааяа зөвхөн энд, тэнд бэхийн ором үлдсэн байх бол зарим хотгор, гүдгэр хад чулуутай хэсэгт байгаа үг нь хур бороо, нар, салхи шуурганы цохилтод бага өртсөн учраас харьцангуй тод байдалтай байна.

Ийнхүү анхны судалгааны үр дүнд уйгуржин монгол, хятад, дөрвөлжин үсэг болон кидан болон зүрчин үг бүхий бичээсийн үлдэгдэл нийт арван хэдэн хэсэг байгааг илрүүлсэн болно.

Үүний дараа, бид 2019 оны 5-р сард, дурдсан Гуаншинюань тосгоны ойролцоо байгаа Ихэчэн (义合成 Yi he cheng) тосгонд очин, тосгоны арын уул, хадыг судалсан ба энэ үед уйгуржин монгол, дөрвөлжин үсэг, хятад, төвд үсгийн бичээс шинээр олсноос гадна, Христосийн шашны загалмай тэмдэг бүхий зураас байсныг илрүүлэн тогтоолоо.

Их Хянган давааны урд хэсэгт энэ мэт нилээд тооны бичээс, тэрчлэн олон төрлийн үсэг бичиг жич тэмдэг, зураг байгаа нь өмнө нь Монгол Улсын нутагт цөөн илэрснийг эс тооцвол, өөр улс орон дахь хадны бичээсэнд тун цөөн байгаагаараа онцлог болж байна. Ялангуяа уйгуржин монгол үсэг болон дөрвөлжин үсгийн бичээсүүд нь эртний бичлэгийн хэлбэр шинжээ илт хадгалсан байгаа ба Их Монгол улс болон Монголын Юань улсын үеийн албан бичгийн хэв хэлбэртэй, нэн сонирхолтой нь хятад бичээсэнд:

“Жиюаний арван тавдугаар он”

гэж тодорхой он жил байгаа нь 1278 он буюу Хубилай хааны үетэй холбогдож байгаа болохоор, гарцаа байхгүй Монголын дундад эртний үсэг бичиг, түүх соёлын өв материал болох нь илэрхий.

Он цагийн уртад ихэд балархайшиж, уншихад бэрх, хүчиртэй болсон нь маш харамсалтай хэдий ч, зарим үлдэгдэл ул мөрийг нь нарийвчлан шинжлэн үзсэний эцэст, эл бичээс нь Монголын эртний түүх соёлтой гүнээ холбогдож байгаа нь мэдэгдсэн тул, энэ талаасаа уг бичээс тун үнэ цэнтэй дурсгал болж байгаа юм.

Миний бие энэхүү өгүүлэлдээ эдгээр бичээсийн дундаас дөрвөлжин үсгээрх бичээсийг тусгайлан сонгон авч танилцуулахын хамт, анх алхам судлан шинжилж дүгнэлтээ дэвшүүлж байгаа юм.

Өдгөө болтол уламжлагдаж ирсэн дөрвөлжин үсгийн монгол бичгийн дурсгалд цаас, хөшөө чулуу, бурхант агуй, суварга болон төмөрлөгийн зүйл дээр бичигдэж үлдсэн зүйл өдий төдий байдаг. Харин хөдөө хээрийн хадны бичээсний зүйл цөөн, өнөө хэр эрдэм шинжилгээнийхэнд мэдэгдэж байгаа нь Монгол Улсын Дархан хотын ойролцоо Хүйтэний голын дөрвөлжин үсгийн хадны бичээс, Хэнтий аймгийн Рашаан хадын дөрвөлжин үсгийн бичээс гэх мэт цөөн үлдэгдэл байна.

БНХАУ-д урьд өмнө энэ тухай мэдээ баримт ерөөс байгаагүй бөгөөд ойрын жилд бидний Их Хянган давааны хадан бичээсийн хайн байцаалтаар сая шинэ зүйлийг илрүүлж байна. Тиймээс бид энд, Хишигтэн хошууны Зуухын голын дагуу хийсэн судалгаагаараа шинээр илрүүлсэн дөрвөлжин үсгийн хадны бичээсий тухай анхны ажиглалтаа олонд толилуулж, байгаа нь, тэрхүү хоосныг нөхөх ач холбогдолтой хэмээн үзэж байна.

I. Гуаншинюаний дөрвөлжин үсгийн бичээс

Гуаншинюань (广兴源 Guang xing yuan) тосгон нь Бяруу балгасаас Жируй балгас 芝瑞镇 Zhi rui zhen) хүрэх замд байдаг. Тус тосгонд байгаа нэг бүлэг хадны бичээс дотроос дөрвөлжин үсгийн бичээсийн ул мөр нэлээдийг олов. Тэр бичээс нь уйгуржин монгол, хятад, кидан буюу зүрчин үсэг бичээс бүхий нүүр хадны зүүн захын хамгийн доор хэсэгт бий. Энэхүү байрлалаар нь ажиглаваас бусад бичээсээс зайлсхийж, хамгийн сүүлд нь бичсэн болов уу гэмээр байна. Харамсалтай нь дөрвөлжин үсгийн бичээс нь бүгд элэгдэж балраад, өндөр, богино, их багын хэмжээ төлөв нь мэдэгдэхгүй болжээ.

Одгөө зөвхөн 7-8 мөрийн ул мөр харагдах ба 𐰽 𐰺 𐰽 𐰽 (bi-či-b) гэсэн нэгэн үг хамгийн эцсийн мөрөнд тодорхой үлдсэн байна (Зураг I). Харин бусад мөрөнд 𐰽 𐰽 (gè), 𐰽 (r) , 𐰽 (q) гэх мэт бичлэг энд, тэнд бүдэг харагдах төдий. Нарийвчлан ажиглаваас, энэ эцсийн мөрийн дээд захад дөрвөлжин үсэгтэй бараг давхцах шахуу ойрхон зайнд уйгуржин монголоор “𐰽𐰽” гэдэг үг байгаа нь, энд хоёр зүйлийн монгол үсгийн бичээс зэрэгцэн оршиж байсан нь илэрхий ажээ.

Энэхүү 𐰽 𐰺 𐰽 𐰽 гэдэг үгийн бэхийн өнгө нь нилээд өтгөн, урт нь 7 см, маш хичээнгүй тигээр бичигдсэн бөгөөд үүнийг үсгийн бүтцээр галиглаваас bi-či-b болно. Бусад олдсон дөрвөлжин бичгийн дурсгалд бараг бүр 𐰽 𐰺 𐰽 𐰽 𐰽 𐰽 (bi-či-beè) гэсэн нэгхэн бүтэц бөхий бичигдсэн байдаг¹. Энэ хадны уул үг нь элэгдэн балархайшиж, үгийн эцсийн 𐰽 𐰽 (eè) нь арилаад, дутуу заримдаг үлдсэн гэмээр. Гэхдээ энд уул үсэг нь 𐰽 𐰽 𐰽 𐰽 𐰽 𐰽 (bičibe) гэж байснаас зөвхөн 𐰽 (e) нь баларсан гэдгийг ч, үгүйсгэхийн аргагүй юм. Учир нь дөрвөлжин бичигт монгол хэлний үйл үгийн өнгөрөн төгссөн цагийн хэлбэрийн дагавар нь 𐰽 , 𐰽 𐰽 , 𐰽 𐰽 / 𐰽 𐰽 𐰽 , 𐰽 𐰽 𐰽 гэсэн хэдэн хэлбэрээр бичигддэг ба энэ нь XIII-XIV зууны уйгуржин монгол бичгийн =ba,=be,= bi / =bai,=bei үндсэн хэлбэртэй тохирч байдаг. Бидний үед уламжлагдан ирсэн, “Монголын нууц товчоон”-ы хятад галигийг ажиглаваас: эр, эм гэж ялгалгүйгээр, ихэнхдээ “罷” (ba) үсгээр энэ хэлбэрийг галигласан байдаг ч, угтаа “别” (bie), “伯” (bo, bai, ba) гэх мэтээр ялгаатай байсан үгсийг орлуулан сольсон гэдгээ “уул нь ‘别’ үсэг байсан” (原作别 yuan zuo bie), “уул нь ‘伯’ үсэг байсан” (原作伯 yuan zuo bai) хэмээн тус, тусын үгийнх нь дагууд нь илэрхийлсэн байдгаар нь мэдэж авдаг. Тэгээд орлуулахаас өмнөх тэр нэгэн зүйлийн хятад галигийн эх бичигт “罷 ba” (цөөн тохиолдолд “八 ba”, “巴 ba”=ba), “别 bie” (=be), “伯 bai” (=bai,=bei), “

¹ Дөрвөлжин үсгийн материалыг Хөгжилт, Саруулын найруулсан Ba si ba zi meng gu yu wen xian hui bian, nei meng gu jiao yu chu ban she, 2004 (“八思巴字蒙古语文献汇编”, 内蒙古教育出版社, 二〇〇四年); D. Tumurtogoo, Mongolian Monuments in 'Phags-Pa Script, Taipei, 2010. Уйгуржин монгол үсгийн материалыг Товуугийн зохиосон “Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичигүүд” (Үндэстний хэвлэлийн хороо, 1983 он); D. Tumurtogoo, Mongolian Monuments in Uighur-Mongolian Script (XIII-XVI centuries, Taipei, 2006. Турфаны олдворыг Dalantai Cerensodnom, Manfred Taube, Die Mongolica der Berlin Turfansammlung, (Akademie Verlag, 1993), Хар хотын олдворыг Yoshida Junyichi, Chi me do do ru ji hen, Harahoto shutsudo mongoru monjyo no kenkyū, yūzankaku, 2008. (吉田順一、チメドルジ編: “ハラホト出土モンゴル文書の研究”, 雄山閣、二〇〇八年)-аар тус, тус лавлалт болгов.

畢 bi” (= bi) үгүүдээр үйл үгийн өнгөрөн төгссөн цагийн хэлбэрийн дагаварыг галиглаж байсан нь тодорхой юм.

Хар хотын олдвор, Турфаны олдвор, Ил хаадын зарлигийн бичиг зэрэг уйгуржин монгол бичгийн дурсгалуудад “”, “” гэж хоёр хэлбэрээр гардаг. Үүнээс мэдэж болох зүйл гэвэл, авч үзэж байгаа дагаврын хэдэн хэлбэрийн бичлэг нь нилээд урт хугацаанд тогтвортой зэрэгцэн оршиж байсан байна. Бидний судлан буй Хишигтэн хошууны хадны уйгуржин монгол үгийн бичээсэнд “” гэж хоёр удаа гарч байгаагаас, энэ хаданд байгаа уул дөрвөлжин үсэг бүхий үгийн бичлэгийн талаар дээрх төсөөлөл хийх боломж олгож байна.

Нөгөө талаар энэ “бичив”, “бичвэй” гэдэг үг нь албан бичгийн найруулга, хэлбэрийн төгсгөлийн үгэнд гардаг журамтай учраас, уул бичээс нь нэгэн бүрэн бүтэн албан бичгийн шинжтэй зүйл байсан гэж үзэх ёстой. Хэрвээ хаад ноёдын зарлигийн бичиг байваас эрхбиш:

“Мөнх тэнгэрийн хүчин дор”,

“Их суу залийн ихээхэнд, ...зарлиг ману”,

“Тэнгэрийн хүчин дур, хааны суу дор, ... үг ману”

гэх мэт хэвшмэл эхлэлтийн үг дутагдаж болохгүй бөгөөд үүний дараа гол явдлаа тоочин, хэзээ, хаана бичсэн гэдгээ илэрхийлж төгсгөл болгодог ёстой. Энэ бүх агуулгыг энэ бага зайнд багтаах боломж арай байхгүй учраас, тус дөрвөлжин үсгийн бичээс нь даанч охор авсаархан, хаад ноёдын буулгасан зарлигийн бичгийг хуулбарласан боломж алга учраас ерийн замын ерийн бичээс тэмдэглэлийн зүйл байсан болов уу гэмээр.

Өөрөөр хэлбэл тус хадан дээрх бусад уйгуржин монгол бичээстэй адил энэ газар, хэн, хэзээ, юунд ирсэн ба хэн бичсэн гэх мэтийн агуулгатай аяны хүмүүний замын бичээс байсан гэж магадлаж болно. Иймэрхүү уйгуржин монгол үсгээрх аян замын бичээс Дуньхуаны бурхант агуйд нилээд харагддаг ч, дөрвөлжин бичгийн үлдэгдэл дурсгал маш цөөн. Өдгөө бидэнд уламжлагдаж ирсэн XIII-XIV зууны дөрвөлжин бичгийн дурсгал гэвэл: Хубилай сэцэн хаан болон түүнээс хойших хаадын зарлигийн бичиг, хааны хатны иж бичиг, хаан тайжийн линж бичиг, хааны багш нарын фаж бичиг, зар тунхаг, Цавчаал боомтын хананы бичиг, пайз гэрэгэ тэмдэг, тамга тэмдэг, зоос мөнгө, “Эрдэнийн сан субашид”, гэрээ бичиг, шашны судар гэх мэтийн зүйлүүд бий. Тэгээд голдуу дээд дэсийн албан байгууламж, соёлын хүрээнд хэрэглэгдэж байсан тул, түүний бичгийн ёс дүрмийг гүйцэд эзэмшигчид олон тооны байж чадахгүй, ийнхүү аян замын бичээсийг чөлөөтэй бичиж чаддаг нь нилээд өндөр зэргийн боловсролтой бичээч буюу албан тушаалтан, эсвэл ном судар орчуулагч л байж таарна.

II. Ихэчэн тосгоны дөрвөлжин үсгийн бичээс

Ихэчэн (义合成 Yi he cheng) тосгон нь Бяруу балгасаас 30 гаруй километр зайтай, Гуаншинюань (广兴源 Guang xing yuan) тосгоноос 10-аад км-т Зуухын

голын хөвөөнд байрладаг. Тус тосгоны арын хадтай ууланд нэгэн бүлэг бичээс байсныг Гуаншинюань тосгоны бичээсийг судлах хоёр дахь удаагийн шинжилгээний үед шинээр олж илрүүлсэн билээ. Судалгааны явцад энэ хаднаас уйгуржин монгол бичээс, төвд бичээс, төвд монгол хавсаргасан бичээс, дөрвөлжин үсгийн бичээс, хятад бичээс, христосын загалмай тэмдэг илрүүллээ. Үүнд дөрвөлжин үсгийн бичээс нь нийт 3 хэсэг байна. Доор тус, тусад нь тайлбарлан өгүүлье.

1. Нэгэн зарлигийн бичгийн үлдэгдэл.

Тус дөрвөлжин үсгээрх бичээсийн мөрийн тоо болон өргөний хэмжээ нь сайтар мэдэгдэхгүй, өндрөөрөө 70 см, нилээд сонгож бичсэн тиг байна. Ихэнх нь элэгдэж баларчээ. Гэсэн ч уг бичээсийг өндөр нарийвчлал бүхий орчин үеийн фото зургийн аппаратаар авсан зургаа компьютерийн тусламжтайгаар улам нарийсган тодруулж, сайтар нягталж үзвэл, зөвхөн түрүү гурван мөрний эхний хэсэг нь л танигдаж байна. Энэ бүхнийг сийрүүлж, үсэгийн бүтцийн галиг хийгээд авианы галигийн дарааллаар галиглаваас (Зураг II):

1. 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 ...

q·-nu-su-dur

qān-u su-dur

2. ... 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 ...

Nḡ-gi-yd-jin

naṅgiyadjin

3. ... 𐰇𐰏𐰤𐰣 [𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣] 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣

ge-[un-ju]-·eu-ge-m-nu

g[ünj jü] üge manu

1. 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 ...

q·-nu-su-dur

qān-u su-dur

2. 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 ...

Nḡ-gi-yd-jin...

Naṅgiyadjin

3. ... 𐰇𐰏𐰤𐰣 [𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣] 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣 𐰇𐰏𐰤𐰣

ge-[un-ju]-·eu-ge-m-nu

g[ünj jü] üge manu.

Үүнийг орчин цагийн монгол хэлээр буулгаваас доорх мэт:

1. хааны суу дур

2. Нангиаджин...

3. ... гүнж үг ману

(1). “**Хааны суу дор**”. Энэхүү үг нь дөрвөлжин бичгийн дурсгалуудтай адил буюу нэгдэлтэй байна. “Хаан” гэдэг үг уйгуржин монгол бичгийн дурсгалд анх “Шагжаа сүмийн хөшөөний бичиг”-т: “” гэж дусалтай бичигдсэн ба бусад олонх байдалд: “” “ **б**” гэж бичигдэнэ. Олны мэдээжээр, энэ үгэнд дөрвөлжин бичгийн үндсэн бичлэгийн хоёр томоохон онцлог холбогдож байгааг энд цухас дурдвас, нэгд, уйгуржин монгол бичигт урт эгшгийн тусгай тэмдэг үсэг гэж үгүй байхад, дөрвөлжин бичигт энэ   (q-nu / qān-u) мэтээр аливаа урт эгшиг тохиолдох нөхцөлд уртатгал  хэрэглэгддэг нэгэн онцлог болно. Хоёрт, уйгуржин монгол бичгийн үсгийг угсран бичээд тийн ялгалуудыг залгах буюу саланги бичдэг нь алтай язгуурын залгамал хэлний онцлогтой нийцдэг, харин дөрвөлжин үсэг нь дээрх “хаан” гэх үг мэт “n”-аар төгссөн үгэнд харьяалахын тийн ялгал “-u” залгахад “n” нь хойнох дагавартайгаа нэгдэж үе бүтээдэг, харин тийн ялгал залгахгүй бол   гэж нэг үеэр бичигдэнэ. Өөрөөр хэлбэл үеэр нэгж болгохыг урьдал болгосон нь уйгуржин монгол үсгийн ёсноос өсөд өөр, нэгэн зүйлийн бичлэгийн ёс журам болно.

“Суу” гэдэг энэ үгийг хятад хэлний “祚” (zuo) -тай гарал нэгтэй, нилээд эрт уйгур хэлэнд зээлэгдэж, тэндээс монгол хэлэнд нэвтрэн орсон гэж үзэх нь бий². Монгол хэлэнд “суу” гэдэг нь “*өлзий хутаг*”, “*аз буян*”, “*сүр хүчин*”, “*цог заль*” гэх мэт утгатай бөгөөд дундад эртний уйгуржин монгол бичгийн дурсгалд бүр “суу” (suu), “суу дор” (suu-dur), “суу жали” (suu-jali), “суут” (suu-tu), “суу тан” (suu-tan) гэж бүр хоёр эгшигтэй бичигдэж буй. Энэ тухай “Зэвэгтөмөрийн зарлигийн бичиг”³, “Аргун хааны зарлигийн бичиг”, “Хин үн гэгийн хөшөөний бичиг” зэрэг дурсгалуудад жишээ үгс бий. Гэхдээ ийнхүү дөрвөлжин бичигт “su” хэмээн нэгэн адил авиалагдаж буй нь аман аялгуунд богиноор авиалагдаж байснаас шалтгаалсан бололтой. Бас жишээлбэл, “Монголын нууц товчоон”-ы хятад галигт “速突兒” (su-tu-er), “速圖” (su-tu), “速台” (su-tai) гэж байгааг бүр богино эгшиг гэж үзвээс авианы хувьд харин ч дөрвөлжин бичгийн дуудлагатай нийцэж байна⁴. Үүнээс үзвээс, “суу” нь уйгуржин монгол бичигт хэдийгээр давхар эгшгээр бичигдэж байсан ч, аман аялгуунд богиноор авиалагдаж байсан нэгэн ёсны онцгой бичлэгтэй дан үет үгсийн нэгэн гэж үзэж болно. Хожмын сурвалжид мөн “суу” гэсэн бичлэгээ баримталсаар байсан ч, дагавар залгагдах үед “sut”, “süt” гэж дан эгшгээр бичигдэх болжээ.

(2). “**Нангиаджин... гүнж**”. Хүнийн нэр, Хубилай хааны охины нэр юм. “Нангиад” нь бас “нангиас” гэж өгүүлэгдэх бөгөөд хятад хэлний “南家” (nan-

² Сэцэнцогт “Язгуурын толь” (Өвөр монголын ардын хэвлэлийн хороо, 1988 он), 1653-1654 дүгээр нүүр. Мөн Н. Поппе, The Mongolian Monuments in Hp'ags-pa Script. (Otto Harrassowitz. Wiesbaden. 1957. p. 72-76), хятад хэвлэл, Bao pei ba si ba zi meng gu wen xian yu yan jiu ru men, min zu chu ban she, 2008 nian, pp. 170-175. (“鲍培八思巴字蒙古文献语研究入门”, 民族出版社, 二〇〇八年, 第一七〇—一七五 页)-д дэлгэрэнгүй өгүүлснийг үзмүй.

³ Dao bu, Zhao na si tu, Liu zhao he, Hui hu shi meng gu wen zhi bi tie mu er da wang ling zhi shi du, min zu yu wen, 1998. 2. (道布、照那斯图、刘兆鹤: “回鹘式蒙古文只必帖木儿大王令旨释读”, “民族语文”, 一九九八年第二期).

⁴ “Монголын нууц товчоон”-ы 111, 272, 275 -р зүйлүүдэд лавламуй.

jia)-д олон тооны дагавар залгаж бүтсэн үг. Алтан улсынхан Сүн улсыг “南家” (nan-jia) буюу “南家子” (nan-jia-zi) гэж нэрлэдэг байснаас үүсэлтэй ажээ⁵. Өмнөд Сүн улсыг хэлж байсан энэ үгээр хожим нь бүх Хятад болон хятад иргэдийг нэрлэх болжээ. Жишээ нь: Ил хаант улсын “Өлзийт султаны зарлигийн бичиг” (1305)-т: “*наран ургухуй нангиасын газар*” гэх. XIII-XIV зуунд монголчууд эзэлсэн орон буюу угсаатныг өөрсдийнх нь нэр хоч ашиглаж нэрлэх явдал зөндөө бий. Жишээ нь: “Юань улсын судар”-т: “囊嘉特” (nang-jia-te), “囊加台” (nang-jia-tai), “南家带” (nan-jia-da), “囊家带” (nang-jia-dai) гэх мэтээр гарах ба “Хуа и и юй” (А дэвтэр)-ийн харилцааны бичгийн “Мянган мэдэх нангиасын бичиг” (曩加思千户狀 nang-jia-si-qian-hu-zhuang) гэх мэт байна. “Жи юан и юй” толь бичигт: “нангиадай” (囊家歹 nang-jia-dai)⁵ гэж байдаг.

Энд “үг мана” гэснээр, тус хадан бичээс нь Хубилай хааны охин Нанхиаджин гүнжийн буулгасан зарлигийн бичгийг хуулбарласан зүйл болохыг илэрхийлж байна. Нанхиаджин гүнж бол хонгирад түмний Начин ноёны хөвгүүн Олчины хатан байв, Олчин зуурмаг нас нөгчсөний дараа түүний дүү Төмөртэй суусан боловч удалгүй Төмөр нөгчөөд түүний дүү Манждайтай сууж хонгирдын засгийг бараг гуч гаруй жил барилцжээ. Тэрээр хонгирадын Бар хот, Бор хотуудыг бүтээн байгуулсан бөгөөд улс төр, соёлын гарамгай зүтгэлтэн байж монголын түүхэнд алдаршсан юм. Хубилай хааны *жиюаний* арван дөрвөн он (1277) онд, Олчины нөгөө нэг дүү Зургаадай нь Ширгэ ноёны үймээнийг дагаж хонгирдад урвалга гарган Бар хотыг дайлж ах Олчиныг хөнөөсөнд, Хубилай хаан монгол, солонгос, жүрчин, хятад цэргийг умардад шилжүүлж Зургаадайг дарах үед Нанхиаджин гүнж түүнд тусалж гол үйлдэл үзүүлжээ.

Зуухын голоос “жиюаний арван тавдугаар он (1278)-ы” хадан бичээс илэрч байгаагаар яг тэр түүхэн явдалтай нягт холбоотой нь тодорхой байна. Тус хадны бичээс нь Нанхиаджин гүнж тухайн үед эл талд зарлиг буулгаж ноёлох байранд байсныг илэрхийлж байна. Үүнээс гадна бид Бар хотын ойролцоо Далай нуурын хөвөөнөөс “түмний ноён Нанхиаджин” гэсэн уйгуржин монгол үсгийн бэхэн бичээсийг олсон билээ. Эдгээр нь Олчин ноёны дараа, хонгирдын түмний ноёны зэргийг Нанхиаджин гүнж залгамжилж явсныг гэрчилж байна.

(3). *Албан бичгийн найруулгын хэв*. Юуны өмнө үүнд “хааны суу дор”, “үг ману” зэрэг үг илэрч байгаагаар нь Юань улсын үеийн хаад ноёдын зарлигийн бичиг зэрэг албан бичгийн эхлэлтийн үг болохыг хялбархан мэдэж болно. Тухайн үеийн албан бичгийн найруулгын хэв ёсонд эхлэлтийн үг нь эзэн биеийнхээ холбогдлоороо маш чанга тогтсон хэллэгтэй байдаг. Үүнд хаадын зарлигийн бичиг нь:

“Мөнх тэнгэрын хүчин дур
Их суу залийн игээн (ивээн) дор
Хааны зарлиг ману”

гэж, хатдын зарлигийн бичиг нь :

⁵ Fang ling gui, Yuan ming xi qu zhong de meng gu yu, han yu da ci dian shu ban she, 1991 (方龄贵: “元明戏曲中的蒙古语”, 汉语大词典出版社, 一九九一年, 第二五八一—二六六页).

“Мөнх тэнгэрийн хүчин дор
Хааны суу дор
Хуантайху иж ману”

гэж, хаан тайж болон ван ноёдын зарлигийн бичиг нь :

“Мөнх тэнгэрийн хүчин дор
Хааны суу дор
... Үг ману”

гэх буюу зарим орон нутгийн ноёд нь:

“Тэнгэрийн хүчин дор
Хааны суу дор...
үг ману”

гэж, хааны багш (дийш 帝师 di-shi) нарын зарлигийн бичиг нь :

“Хааны зарлигаар
... фаж ману”

гэж бичигдэнэ. Өөрөөр хэлбэл, албан бичгийн эхлэлтэд хэрэглэх үгс нь тус тусынхаа зэрэг дэсээр ялгаатай байна. Үүнд: Хааны зарлигийн бичигт байгаа “*их суу залийн игээн (ивээн) дор*” гэдэг хэллэг нь хатад, тайж, ван ноёдын зарлигийн бичигт эрхбиш “*хааны суу дор*” гэж, “*зарлиг ману*” гэдгийг хатдын зарлигийн бичигт “*иж ману*” гэж, тайж, ван ноёдын зарлигийн бичигт “*үг ману*” гэж тус тус ялган бичих ёстой ажй. Бас, жишээлбэл, Монгол Улсын Хүйтэний голын дөрвөлжин үсгийн хадны бичээс нь:

*Мөнх тэнгэрийн хүчин дор
Их суу залийн игээн дор
Хааны зарлиг*

гэж байдаг нь тэр хэвээрээ хаан эзний зарлигийн бичгийг хуулбарласан зүйл болох юм⁶.

Харин хааны гүнжийн бичиг нь “ хааны сууд... гүнж үг мана ” гэж энд анх удаа гарч байгаа бөгөөд дайж, ван ноёдын зарлигийн бичигтэй адил хэлбэртэй байсаныг харуулсан байна.

⁶ “Ши лин гуан жи”, Yuan tai ding kan ben, Shi lin guang ji, Zhi yuan yi yu, ren shi men, (元泰定刊本“事林广记”, “至元译语·人事门”). Харгуулсан шинжлэлийг Jia jing yan, Zhu feng, Meng gu yi yu, Nü zhen yi yu hui bian, tian jing ren min chu ban she, 1990. (贾敬颜、朱凤: “蒙古译语 · 女真译语汇编”, 天津人民出版社, 一九九〇年)-д, бас Товуу “Уйгуржин монгол үсгийн дурсгалт бичигүүд” Үндэстний хэвлэлийн хороо, 1983 он, 501-695-р нүүрд лавламуй.

2. Юань хэмээх нэгэн үсэг.

Дээр дурдсан албан бичгийн үлдэгдэлээс бага зайтай доор талд **ᠶ ᠠ ᠤ ᠡ** гэсэн нэгэн маш хичээнгүй тэгшхэн тигээр бичигдсэн, дөрвөлжин үсгийн гагц үлдэгдэл бий (Зураг III). Бүтэц нь “veon” болох ба “цеон” гэсэн авиа дуудлагатай байна. Үгийн бүтэц болон авианаас энэ үсэг нь монгол үгийг галигласан биш, хятад үгийн галиглал гэж төсөөлж болно. Энэ авианд хамгийн ойролцоо хятад үсэг гэвэл 元, 院, 原, 袁, 阮 гэх мэтийн “yuan” авианы үсгүүд байгаа боловч дөрвөлжин үсгээр Юаний үеийн хятад үсэг бичгийн авиа дуудлагыг тэмдэглэсэн “Мэнгу зи юнь” (蒙古字韻 *meng-gu-zi-yun*, монгол үсгийн эгшиглэл), дөрвөлжин үсгээр хятадын бүгд овгийг тэмдэглэсэн “Бай жиа шин” (百家姓 *bai-jia-xing*, иргэдийн овог)⁷ жич аливаа албан бичиг, тамга тэмдэг, зоос мөнгөний дурсгалд нэгэн жигдээр **ᠶ ᠠ ᠤ ᠡ** (’цен) гэж бичигдээд ярони **ᠤ** (о) жийрэглэж орсон жишээ огт үгүй. Энд юунд ингэж бичигдсэн вэ?

Монгол хэл авианд холбогдох уу? эсвэл хятад хэл авианд холбогдох уу? гэдгийг цаашид шинжлэх чухалтай, харин одоохондоо зөвхөн дөрвөлжин бичиг зохиогдсон эхний үед ийн нэгдэлгүй бичигдэж байсан бололтой гэж үзнэ. Ялангуяа “Их Юань улс” гэдэг улсын нэрийдлийн “Юань”-г анхны шатанд ингэж хүндэтгэл хандуулж онцлон тэмдэглэж байсан ч байж мэдэх юм. Учир нь арай зэрэгцээ биш боловч мөн уул дөрвөлжин үсгийн хажуу ойрхон “至元十五年” (*zhi-yuan-shi-wu-nian*) гэж, даруй “*Жиюаний арван тавдугаар он*” гэсэн Хубилай хааны оны цолтой 1278 оны хятад үсгийн бичээс илэрч байгааг үүнтэй холбогдуулан үзэж болно. Тийм бол энэ үг нь Хубилай хааны оны цол “Жи юань” (至元 *zhi-yuan*) гэсний “Юань”-ы галиглал гарцаагүй мөн бөгөөд “Жи” нь баларсан төдий, энэ нэрийдэл нь дөрвөлжин үсгийн дурсгалд цөмөөр **ᠶ ᠠ ᠤ ᠡ** (ji ’цен) гэж, уйгуржин монгол бичгийн дурсгалд “**ᠶ ᠠ ᠤ ᠡ**” гэж бичигдэж буй⁸.

3. Дөрвөлжин үсгийн цагаан толгойн үлдэгдэл

Тус бичээсний эхний хоёр мөр нь бүрэн бүтэн, гуравдугаар мөрд нэгэн үсэг харагдаж буй, уншваас дөрвөлжин үсгийн цагаан толгойн түрүүчийн хэдэн үсэг болох ажээ. Хойшоо баларсан боловч бас хэдэн мөр бичиж байсан орон зай бий тул, уул нь дөрвөлжин үсгийн цагаан толгой бүрэн гүйцэд бичээстэй байсан гэж үзүүштэй. Энэ гурван мөрийг сийрүүлж, эгшиг дагуулан галиглаваас доорх мэт (Зураг IV) :

1. **ᠡ ᠡ ᠡ ᠡ** (ka k’a ga ŋa)
2. **ᠡ ᠡ ᠡ ᠡ** (ča č’a ja ŋa)
3. ... **ᠡ** ... (..... da ...)

⁷ Хөгжилт, Саруулын найруулсан, *ba si ba zi meng gu yu wen xian hui bian, nei meng gu jiao yu chu ban she*, 2004 (“八思巴字蒙古语文献汇编”内蒙古教育出版社, 二〇〇四年), 森安孝夫・オチル (Ocir) 1999:“モンゴル国現存遺跡碑文調査研究報告”, 中央ユーラシア研究会, pp. 266-268.

⁸ “Үн нам он ганжуур номыг дэлгүүлэхийн хөшөөний бичиг”, Товуу “Уйгаржин монгол үсгийн дурсгалт бичигүүд” үндэстэний хэвлэлийн хороо, 1983 он, 307-318-р нүүр.

Ийнхүү бийр бэх зарцуулж тусгайлан дөрвөлжин үсгийн цагаан толгойг уул хаданд бичсэн нь сонирхолтой юм. Бодвоос мөн дөрвөлжин үсэг зохиогдсон эхний шатанд боловсрох түгээмэлжүүлэхийг уялдуулсан бичээс бололтой. Турфаны олдвор дотор ч дөрвөлжин үсгийн цагаан толгойг бичсэн бүрэн бус цаасны тамтархай бий⁹. Сийрүүлбээс доорх мэт (Зураг V):

.....	(... ...)
ᠮ ᠨ ᠬ ᠭ	(č č' j ŋ)
ᠯ ᠭ ᠨ ᠨ	(t t' d n)
.....ᠨ	(..... m)
ᠪ ᠪ ᠨ	(ts ts' zd)
ᠸ ᠮ ᠸ ᠪ	(ž z · y)
.....	(... ...)
ᠬ ᠪ ᠨ ᠨ	(h ' i u)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(è o q γ)
.... ᠨ ... ᠬ	(... r ... j)

Энэ нь хэдийвээр дутуу дурган үлдэгдэл байсан ч “Шу ши хуй яо” бичиг (書史會要 shu-shi-hui-yao, “Уран бичлэгийн түүхийн хураангуй”), “Фа шу ко” бичиг (法書考 fa-shu-kaoy, “Уран бичлэгийн шинжлэл”) зэрэг Юань улсын сүүлчийн үеийн хятад мэргэдийн туурвисан сурвалжид тэмдэглэгдэн үлдсэн дөрвөлжин үсгийн цагаан толгойн дэс дараалалтай ерөнхийдөө зохицож байгаа нь илэрхий байна [11]. Жишээлбэл “Шу ши хуй ёо” бичигт нийт 41 үсгийг доорх мэт дараалуулан тэмдэглэсэн байдаг (Зураг VI).

ᠮ ᠮ ᠮ ᠮ	(k k' g ŋ)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(č č' j ŋ)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(T t' d n)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(p p' b m)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(ts ts' zd w)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(ž z · y)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(r l š s)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(h ' i u)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(è o q γ)
ᠮ ᠮ ᠮ ᠮ	(hv q e j e)

Хэрэв үсгийн бичлэгийн тэгш хазгай буюу зарим үсгийн хэв дүрс алдагдсаныг гаргавал, нөгөө нэг “Фа шу као” бичгийн тэмдэглэл нь энэ “Шу ши хуй яо” бичгийн тэмдэглэлтэй үндсэндээ адилхан байна (Зураг VII). Хишигтэн хошууны энэ хадны бичээсэнд байгаа цагаан толгойн эхлэлтийн хэдэн үсгийн дэс дараа нь ч эдгээртэй таарч байна. Иймийн тул хятад бичгийн мэргэдийн зохиолд

⁹ Luo chang pei, Cai mei biao, Ba si ba zi yu yuan dai han yu, zhong guo she hui ke xue chu ban she, 2004. 罗常培、蔡美彪“八思巴字與元代漢語”中国社会科学出版社，二〇〇四年。


хуулбарлагдсан, баруун орны Турфанд хүмүүсийн боловсролд хэрэглэгдсэн, мөн Их Хянган давааны энэ хаданд бичигдсэн хэдэн зүйл хоорондоо нэгдэлтэй байсан байдлаас, аль ч шатанд дөрвөлжин үсгийн цагаан толгойн үндсэн жагсаалт ямар байсан нь нэгэн хэмжаанд тодорхой ажээ. Гэхдээ хятад сурвалжид дамжин хуулбарлагдсан тэр нь хоорондоо ерөнхий тоо нь нэгдэлгүй, заримд нь үсгийн дүрс хэлбэр нь хэвээ алдаж буруу хуулбарлагдсан илэрхий зөрөөтэй зүйл ч оршино. Эдгээр нь дөрвөлжин үсгийн авиа зүй, үсэг зүй судлалд саад болох талтай юм. Тиймээс түүнийг лавшруулан шалгах эхний үеийн баттай баримт материал маш хэрэгцээтэй байсаар, харамсалтай нь Хишигтэн хошууны хадны бичээс нь элэгдэж балраагүй байсан бол Хубилай хааны үед бичигдсэн нилээд эртний цагаан толгой байсан мөртөө бусад тэмдэглэлүүдыг шалгаж үзэх нөхцөлийг хангах боломж бүрэн байсан юм.

ТӨГСГӨЛ

Хураангуйлж хэлбэл: Өвөр Монголын Хишигтэн хошууны Зуухын голоос шинээр олдсон дөрвөлжин үсгийн хадны бичээс нь хятад бичээсэнд илэрсэн Жиюаний арван тавдугаар он (1278)-той холбоотой гэж үзвэл, бичигдсэн цаг үе нь Хубилай хааны үе болох юм.

1269 онд Хубилай хааны зарлигаар Пагва лам дөрвөлжин үсэг зохиож “Монгол шинэ үсэг” хэмээн төрийн албанд хэрэглэж эхэлснээс төдий удаагүй цаг үе болно. Хадны бичээсүүд нь хэдийгээр ул мөрийн төдий үлдэж байгаа боловч, түүнд аян замын бичээс, ван ноёдын албан бичгийн хуулбар, хааны оны цолтой тэмдэглэл, дөрвөлжин үсгийн цагаан толгой гэх мэтээр янз бүрийн үсэг бичгийн төрөл зүйл холбогдож байгаагаас нь тухайн үед тус нутаг оронд дөрвөлжин үсэг нэгэнт өргөн хүрээ, хэвцээнд хэрэглэгдэж байсныг мэдэж болно. Улмаар үг, үсгийг нэг бүрчлэн нягталбаас дөрвөлжин үсгийн эхний үеийн зарим бичлэгийн онцлог харагдах төдийгүй, бас түүнд дундад эртний монгол хэл, үсэг зүйн зарим нэгэн үндсэн тогтолцоо холбогдож байна. Бас Нанхиаджин гүнжийн зарлигийн бичиг хуулбарлагдан үлдсэн ба хятад, уйгуржин бичээстэй он жилийн тодорхой холбогдол гарч байгаа нь тухайн үеийн улс төр, цэрэг дайны томоохон хэрэг явдлыг лавшруулан судлах бодитой материал болох юм.

Ийнхүү Хишигтэн хошууны Зуухын голын хадны бичээс нь монгол үг хэл, үсэг бичиг, түүх соёлын бас нэгэн чухаг дурсгал мөн бөгөөд Дайду хот, Шанду хот, Бар хотыг холбосон өртөө замын байршлаараа, улмаар Монгол хийгээд Их Хянган давааны урагш хойш, баруун зүүнийг холбосон эртний өртөө зам, аяны хаалга дагуух хадны бичгийн бичгийн үлдэгдлийг хайн шинжлэхэд чухал сүвэгчийг бидэнд хангаж байгаа юм.



(Зураг I)



(Зураг II)



(Зураг III)



(Зураг IV)



(Зураг V)

卅	萬	丙	渴	丙	丹	丙	談	丙	者	丙
卅	遮	丙	倪	丙	恒	丙	捷	丙	達	丙
丙	鉅	丙	發	丙	求	丙	麻	丙	撈	丙
丙	惹	丙	縛	丙	若	丙	陸	丙	阿	丙
丙	羅	丙	羅	丙	設	丙	沙	丙	訶	丙
丙	伊	丙	鄒	丙	醫	丙	汚	丙	遐	丙
丙	法	丙	惡	丙	也	丙	品	丙	耶	丙

右借漢字釋音並開口呼之漢字母內則去丙四
 丙三字而增入丙四丙四四字切韻多本梵法或
 一母獨成一字或二三母揅成一字如丙天丙
 地丙人丙三東丙西丙南丙北之類是

(Зургаг VI)

文奇字鮮能解者方今聖教遠被重譯來朝遂得親聞呼吸之正研究傳寫之訛車書會同無以加矣惟我皇元兆基朔方俗尚蘭古刻木為信猶結繩也既而頗用北庭字書之羊草猶竹簡也蓋天將徵世以復古奄有中夏未遑於制作乃詔國師拔思巴采諸梵文創為國字其母四十有三

(Зургаг VII)